



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/А/С

Дэлгэрмөрөн

**Засаг даргын нөөц хөрөнгөөс
зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам”-ийн 2.1.6 дахь заалт, сумын Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Монголын бүх ард түмний спортын 15 дугаар их наадам”-ыг аймгийн хэмжээнд 2022 оны 04 дүгээр сарын 10-17-ны өдрүүдэд зохион байгуулах, аймгийн Биеийн тамир спортын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 144 тоот албан бичигт сумын Засаг дарга баг тамирчдыг зохион байгуулалттай оролцоог ханган ажиллахтай холбогдуулан сумын баг тамирчдыг тус спортын их наадамд оролцуулах арга хэмжээг Улаанбаатар хот, бусад аймгуудад ажиллаж амьдарч байгаа шилдэг баг, тамирчдыг оролцуулан зохион байгуулсугай.

2. Спортын 15 дугаар их наадмын зохион байгуулалттай холбоотой тамирчдын ирж очих унааны зардал, байрлах байр, хоол хүнс, спортын хувцасны үнэ, мандатын төлбөрт 2300000 (Хоёр сая гурван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Нягтлан бодогч (Б.Баттөмөр)-д зөвшөөрсүгэй.

3. Анхан шатны санхүүгийн баримтыг бүрдүүлж тайлан тооцоог гаргаж ажиллахыг Нярав (Ц.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Баярсайхан)-д даалгасугай.

ДАРГА



С.СУМЪЯАБАЗАР

D /bichig hereg/ Zahiramj -2022 он

642201045